



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өмнөговь аймаг дахь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын явцад сэргээн засварлах боломжгүй болсон, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй, 7 нэрийн, нийт 7,297,200.00 (долоон сая хоёр зуун ерэн долоон мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Өмнөговь аймаг дахь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Б.Должинсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003003

2022.09.29 22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн
25 дугаар тогтоолын хавсралт



Өмнөговь аймаг дахь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлаж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)
1	Угсардаг самбар	12/12/2011	1	1,400,000.00	1,400,000.00
2	Хүчилтөрөгч коктейль аппарат	12/24/2014	1	1,300,000.00	1,300,000.00
3	Хөлдөөгч	12/25/2014	1	520,000.00	520,000.00
4	Шарах шүүгээ	12/15/2008	1	120,000.00	120,000.00
5	Мотор	8/1/2011	1	1,170,000.00	1,170,000.00
6	Мотор	12/25/2006	1	1,687,200.00	1,687,200.00
7	Угсардаг самбар	11/20/2014	1	1,100,000.00	1,100,000.00
	Нийт дүн		7		7,297,200.00 (долоон сая хоёр зуун ерэн долоон мянга хоёр зуун)